

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 08 дугаар сарын 20

Улаанбаатар хот

ДҮД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хэрэгжилтийн хувь
Үүрэг, даалгавар ДОЛОО: Нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлагдаад амжилтгүй болсон тендерүүдийн шалтгаан нөхцөл болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг танилцуулах.				
1	<p>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 30 дугаар тогтоолын дагуу төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2023-2024 он дамжин санхүүжих болон 2024 онд хэрэгжих нийт 166 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс:</p> <p>28 төсөл арга хэмжээг нийт гурав ба түүнээс дээш удаа зарлахад нэг ч оролцогч тендер ирүүлээгүй тул захиалагчид ажлын даалгавар, тоо хэмжээг хянуулахаар албан бичиг явуулсан. Захиалагч байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирсэн өдөрт нь багтаан төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn болон www.chingeltei.gov.mn цахим системээр дамжуулан ил тод нээлттэй зарлан ажиллаж байна.</p> <p>Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх нийт 17 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг өөрчлөхөөр хянаж байна.</p> <p>3 төсөл, арга хэмжээг хасахаар шийдвэрлэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Жигжидийн амны уулзварын засварын ажил - Насан туршийн Суралцахуйн төвд шаардлагатай тоног төхөөрөмж худалдаж авах - “Нийтлэг үйлчилгээний газар” ОНӨТҮГ-т машин механизм худалдаж авах зэрэг байна. <p>2024 оны 08 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд холбогдох хэлтэс, албад болон 1-24 дүгээр хороодын Засаг дарга нартай уулзалт хийж, худалдан авах ажиллагаа амжилтгүй болж байгаа ажлуудыг танилцуулж, худалдан авах ажиллагаанд оролцогч оролцохгүй байгаа шалтгааныг хэлэлцсэн. Уулзалтаар оролцогчгүй 26 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ их, төсөв магадлагдаагүй тул ажлын тоо хэмжээг багасгаж өөрчлөх шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Нийт 21 төсөл,</p>			30

	арга хэмжээний тоо хэмжээг хянаж өөрчлөхөөр зургийн автортой уулзалт хийж, зөвлөлдөн ажиллаж байна.			
Үүрэг, даалгавар ЁС: Нийслэлийн оршин суугч, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж хууль, журам зөрчсөн, стандартын бус хашаа, хайс барьсан газруудын зөрчлийг арилгах, мөн хоёр дахь түүхий эд, дугуй засвар, бусад зүйлийг авч байгаа газруудын газрыг чөлөөлөх ажлуудаа эрчимжүүлэх.				
2	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж, хууль журам зөрчсөн, стандартын бус хашаа, хайс барьсан газруудын зөрчлийг арилгах ажлын хүрээнд 12 байршлын 436 метр хашаа, хайсыг бүрэн чөлөөлсөн. Үүнд: 3 дугаар хороо, Пэйс молл худалдааны төвийн хойд талд: 36 м 3 дугаар хороо, Алтай центрийн урд талд: 14 м 4 дүгээр хороо, 16/1 дүгээр байрны орон сууцны хашаа: 61 м 4 дүгээр хороо, Барилга ХХК-ний хашаа: 14 м 5 дугаар хороо, 26 дугаар байр, оранж төвийн урд талд: 28 м 5 дугаар хороо, Үлэг гүрвэлийн музейн хашаа: 125 м 5 дугаар хороо, 5 дугаар байрны урд талд: 4 м 5 дугаар хороо, маргад караоке-н зүүн талд: 58 м 5 дугаар хороо, 5 дугаар байрны зүүн талд: 50 м 6 дугаар хороо, Рийч зочид буудал: 28 м 6 дугаар хороо, СУИС-ын баруун талд: бетонон хашаа 6 дугаар хороо, 20 дугаар байрны хойд талд 18 м тус тус байна.			30
Үүрэг, даалгавар АРВАН ХОЁР: Дүүргийн удирдлагууд өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэртээ хот нийтийн аж ахуй, нийтийн эзэмшлийн гудамж зам талбай болон явган хүний зам талбайн нөхцөл байдалтай газар дээр нь явж ажилласан талаар дараагийн Нийслэлийн Удирдах ажилтнуудын Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах.				
3	Дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс, тасгийн удирдлага, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын удирдлагын хамт нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний замын нөхцөл байдалтай газар дээр нь явж танилцсан ба иргэдийн эрүүл аюулгүй орчинд чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлж, явган хүн зорчиход хүндрэлтэй замуудыг сайжруулсан, шинэчилсэн хэсэгт хяналт тавьж ажилласан. Нийтийн эзэмшлийн авто болон явган зам талбайд дараах засварын ажлууд хийгдэж байна. 1, 4, 12, 16, 18 дугаар хороодын борооны ус тогтдог 280 м ² явган зам талбай, борооны усны нөлөөгөөр суларсан, хагарал өгч бутарсан 100 м ² чулуун авто замуудад засварын ажлыг “Чингэлтэй Тохижилт Үйлчилгээ” ХХК хийж гүйцэтгэсэн. 6 дугаар хороо, 5 дугаар сургуулийн зүүн талын иргэд зорчих боломжгүй байсан бөгөөд аж ахуйн нэгж, байгууллагууд нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд			100

	<p>зөвшөөрөлгүй шат довжоо хийсэн байсныг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр буулгаж чөлөөлөн явган хүнийг зам талбайг байгуулсан. Мөн СУИС-ийн баруун урд талын бетонон хашааг буулгаж, оюутан сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх орчин бий болгохоор төлөвлөн ажиллаж байна.</p> <p>1 дүгээр хорооны 18 метр квадрат талбайд газар дор байрлах 3 куб метрийн хэмжээтэй 2 ширхэг ухаалаг хогийн савыг байршуулсан. Тус ухаалаг хогийн савыг дүүргийн бүх хороодод байршуулахаар ажиллаж байна.</p> <p>Барилгачдын талбайн баруун талын явган хүн зорчиход хүндрэлтэй замыг сайжруулж шинэчилсэн.</p>			
Үүрэг, даалгавар АРВАН ЗУРГАА: Хүнд даацын автомашиныг байршуулах 2-3 цэг байгуулах асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.				
4	<p>Дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас дүүргийн 24 дүгээр хороо, Ар согоот зусланд байрлах нэгж талбарын 1501303110 дугаартай 1.3 га газрыг хүнд даацын автомашиныг байршуулах цэг болгох саналтай байгаа бөгөөд одоогийн байдлаар хээрийн судалгаа хийгдэж байна.</p>			30
Үүрэг, даалгавар ХОРИН ДӨРӨВ: Нийслэлийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлоос сэргийлэх зорилгоор “Сэргээгдэх эрчим хүч”-ний талаар танилцуулга бэлтгэж, иргэд олон нийтэд сурталчлан таниулах бэлтгэл ажлыг хангах.				
5	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор 7-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн борооны дараах байршлууд болох нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гуу жалга, далан суваг, айл өрхийн бохирдсон нүхэн жорлонгуудад ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж байна. Тус ажлын хүрээнд нийт 213,569 м² талбайд ариутгал халдваргүйтгэлийг 2024 оны 08 дугаар сарын 12-20-ны агаар мананцраар 2 техник хэрэгсэл, явганаар нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Мөн “Хайрхан хөгжлийн төв” ОНӨТҮГ нь экологийн тэнцвэртэй байдлыг хангах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор сэргээгдэх эрчим хүчийг хэрэглээндээ шинээр нэвтрүүлэн ашиглаж байна. /Задгай талбайн явган хүний замын гэрэлтүүлэг нийт 44 ширхэг/</p>			70
Үүрэг, даалгавар ХОРИН ТАВ: Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, шинэ шийдлийг гаргаж ажиллах.				
6	<p>Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 72, 139 дүгээр сургууль, 258 дугаар цэцэрлэгийн урсгал засварын ажил 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхэлсэн.</p> <p>✓ Ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн хөдөлмөрийн хичээлийн эрэгтэй, эмэгтэй анги шинээр нээж байгаа бөгөөд шаардлагатай засварыг хийж тохижуулсан.</p> <p>✓ 258 дугаар цэцэрлэгийн гадна, дотор камер суулгалт болон сургуулийн гал тогооны засварын ажил</p>			100

	<p>✓ 139 дүгээр сургуулийн халаалт, шугам сүлжээний засварын ажил</p> <p>✓ 18, 33, 39, 83, 124, 221, 9, 102 дугаар цэцэрлэгүүдийн зайлшгүй хийх засварын ажлууд</p> <p>✓ Цэцэрлэгүүд барилгын дээвэр солих, хана тааз будах, халуун усны насос засварлах, цахилгаан халаалтын шугам сүлжээг засах, паар солих засваруудыг тус тус хийж анги танхимыг тохижуулж байна.</p> <p>Сургууль, цэцэрлэгүүдийн урсгал засварын ажлын явц 90 хувьтай байна. Хичээлийн шинэ жилээс өмнө засварын ажлыг 100 хувь дуусган тохижуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар ХОРИН ЗУРГАА: “Сургуулийн автобус”-ны аюулгүй ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, сургуулийн автобусыг мэргэжлийн чиг үүргийн байгууллага болох автобус баазад шилжүүлж, засвар арчлалтыг хийлгүүлэх</p>				
7	<p>Дүүргийн өмчид бүртгэлтэй сургуулийн 7 автобусыг мэргэжлийн чиг үүргийн байгууллагад шилжүүлэх ажлыг дүүргийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын хэсгийн хурлын шийдвэрээр Нийслэлийн төр захиргааны “Авто бааз” УТҮГ-т шилжүүлэхээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 3/700 дугаар албан бичгээр Нийслэлийн Өмчийн харилцааны газарт холбогдох баримт бичгийн хамт хүргүүлж, албан бичгийн хариуг хүлээж байна.</p>			70
<p>Үүрэг, даалгавар ХОРИН ДОЛОО: Нийслэлийн хэмжээнд баригдаж дуусаагүй байгаа сургууль, цэцэрлэгийн барилгын асуудлыг хэрхэн шийдвэрлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг нэгтгэн дараагийн Нийслэлийн Удирдах ажилтнуудын Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах.</p>				
8	<p>Дүүргийн 4 дүгээр хороо, 5 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын ажил 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан гэрээгээр 2024 оны 8 дугаар сард ажил бүрэн дуусах байсан. Өргөтгөлийн барилгын санхүүжилтээс 2024 онд орж ирэх санхүүжилтийн үлдэгдэл 65%-ийг 2025 оны төсөвт суулгахаар төлөвлөсөн байсныг өөрчлөн 2024 онд олгож, одоо барилгын ажил 98%-тай явагдаж байна.</p> <p>- 8 дугаар хорооны 640 хүүхдийн суудал бүхий сургууль: 2024 оны 4 сараас барилгын ажил эхлэн хэвийн явагдаж байна. Суурийн угсралтын ажил, гадна цэвэр, бохир усны оруулга шугам хийгдэж дууссан. Барилгын ажлын явц 20%-тай байна.</p> <p>- 12 дугаар хороонд шинээр баригдаж байгаа 144 дүгээр бага сургууль, 276 дугаар цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлын явц 95%-тай байна. 2023 оны 08 дугаар сарын 30-нд комисс ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авах шийдвэр гарсан боловч үлдсэн ажлаа гүйцэтгэхгүй байгаа тул гэрээг цуцалсан. Нийслэлийн Засаг даргын А/547 дугаар захирамжаар 218.0 сая төгрөгийн үлдсэн ажлын эрх дүүрэгт шилжин ирж Худалдан авах ажиллагааны</p>			100

	<p>алба тендер сонгон шалгаруулалтыг зарласан. Үлдэгдэл төсвийг дүүргийн төсвийн тодотголд тусгахаар төлөвлөсөн.</p> <p>- 19 дүгээр хороонд баригдаж байгаа бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын дотор заслын ажил дууссан, хаалга хулдаас дутуу, халаалт, дулаан аваагүй, гадна фасад, асфальтан замын ажил, гадна цахилгааны ажил дутуу байгаа бөгөөд цонх суулгах болон дээврийн ажил хийгдсэн. Барилгын ажлын явц 80%-тай байна. 2023 оны 12 дугаар сарын 01-нд хүлээлгэж өгөх гэрээтэй байсан боловч гэрээг 2024 оны 10 дугаар сар хүртэл сунгасан. 2024 оны 04 дүгээр сараас ажил эхэлсэн. Гэрээт ажлыг 4 удаа сунгасан, ажил зогсонги удаашралтай байгаа тул Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас гэрээ цуцлуулахаар ажиллаж байна.</p> <p>- 16 дугаар хорооны цэцэрлэгийн гэрээг 2021 оны 11 сарын 10-ны өдөр байгуулж, барилга угсралтын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлсэн. 2022-2023 онд суурийн цутгалт, зоорь 1-2 давхрын каркас угсралтын ажил хийгдээд нэмэлт төсөвгүй тул зогссон. 2023 онд 100.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр санхүүжүүлж байсан бөгөөд 2024 онд санхүүжилт 1.963 сая.төгрөг батлагдсан. Цутгалт, дүүргэлт бүрэн хийгдсэн. 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дуусгах гэрээтэй. Барилгын ажлын явц 50%-тай байна.</p> <p>- Дүүргийн Ерөнхий боловсролын 37 дугаар сургуулийн усан бассейн бүхий спорт заал: Нийт санхүүжилт 7,401,000,000 батлагдсанаас 2024 онд 2,220,300,000 батлагдсан ба тендер шалгарч шавь тавих үйл ажиллагаа хийгдэж, барилгын ажил эхлэхээр хүлээгдэж байна.</p> <p>- Дүүргийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн спорт заалыг буулгаж, усан бассейн бүхий спорт заал шинээр барих нийт санхүүжилт 7,400,000,000 батлагдсанаас 2024 онд 2,220,000,000 батлагдсан ба тендер шалгарч шавь тавих үйл ажиллагаа хийгдэж барилгын ажил эхлэхээр хүлээгдэж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар ГУЧИН ХОЁР: 2024 оны 01-08 дугаар сар хүртэлх Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн бүх үүрэг даалгаврын хэрэгжилтийг байгууллагууд тайлагнаж ажиллах. /Жич:Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага болон Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд ERP чатаар тайлагнах/</p>				
9	<p>2024 оны 01-08 дугаар сар хүртэлх Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн бүх үүрэг, даалгаврын хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн О.Мандахын ERP чатаар тайлагнасан.</p>			100
<p>Үүрэг, даалгавар ГУЧИН ДӨРӨВ: “Шарилжгүй Улаанбаатар” аяны хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, гэр хорооллын гудамж зам талбай болон аж ахуйн нэгж, байгууллагуудын орчны гадна талбайн шарилж, хог хаягдлыг цэвэрлүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудтай уулзаж, орчны тохижилтын ажлыг хийлгүүлэх.</p>				

10	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас уламжлал болгон зарладаг “Шарилжгүй Улаанбаатар” аяныг Нийслэлийн хэмжээнд хоёр үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хоёр дахь үе шат эхлэн хөл газрын ургамлын тоосноос үүдэх харшлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийн тоог бууруулах, хөл газрын ургамлыг тайрах, хадах, зэрэг ажлыг нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, далан суваг, гуу жалга дагуух шарилж луулийг цэвэрлэн ажиллалаа. Дээрх цэвэрлэгээний ажилд дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг даргын ажлын алба, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, тээвэрлэгч байгууллагууд идэвхтэй оролцож, нийт давхардсан тоогоор 3118 гаруй хүн цэвэрлэгээний ажилд хамрагдан 228,598 м2 талбайг цэвэрлэн, нийт 16 рейсээр 23.5 тонн шарилж, луулийг 3 техник хэрэгслээр тээвэрлэн ажилласан.			100
Үүрэг, даалгавар ГУЧИН ЗУРГАА: Нийслэлийн хэмжээнд мал гаргах, эзэнгүй нохой, муур устгах ажлуудаа шуурхай зохион байгуулах.				
11	Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан дүүргийн 1-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт золбин нохой, муур устгалын ажлыг гүйцэтгэгч байгууллага болох “Их булаг” ХХК нь “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК-тай хамтран эрчимжүүлсэн устгалын ажлыг гүйцэтгэн ажиллаж байна. 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нийт 569 золбин нохойг устгалд оруулж ажилласан.			100
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ				75.4%

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Б.МӨНХБАТ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ж.ЛХАГВАСҮРЭН

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ШУУРХАЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ц.БАЛЖИННЯМ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ